



Монголын Үндэсний Худалдаа Аж
Үйлдвэрийн Танхим

БИЗНЕС ИТГЭЭЛИЙН ИНДЕКС

2017 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС

© МҮХАҮТ 2018. "Бизнес итгэлийн индекс-2017" судалгааны зохиогчийн албан ёсны эрхийг МҮХАҮТ эзэмшинэ. Энэхүү судалгааны мэдээллийг цааш түгээж байгаа бол зохиогчийн нэр болон эх сурвалжийг заавал дурдана уу.

Агуулга

1. Оршил	4
2. Судалгааны арга зүй.....	5
3. Судалгааны үр дүн	6
НЭГ. БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС.....	6
ХОЁР. БИЗНЕСИЙН ОРЧИН.....	7
2.1 Бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ.....	7
2.2 Бизнесийн орчны өөрчлөлтийн хүлээлт.....	7
ГУРАВ. БИЗНЕСИЙН АШИГ БА ОРЛОГО.....	8
3.1. Ашиг, орлогын өөрчлөлт	8
3.2. Ашиг орлогын өөрчлөлтийн хүлээлт	8
ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН	9
4.1. Хөрөнгө оруулалтын өөрчлөлт	9
4.2. Хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн хүлээлт.....	9
ТАВ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН	10
5.1 Инфляци	10
5.2 Ажилгүйдэл	11
5.3. Ядуурал.....	12
ЗУРГАА. БИЗНЕСИЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	13
4. Бизнес итгэлийн индексийн голлох үзүүлэлтүүдийн чиг хандлага.....	14
5. Дүгнэлт ...	15

Оршил

МҮХАҮТ-аас 17 дахь жилдээ “Бизнес итгэлийн индекс” судалгааг Улаанбаатар хот, орон нутгийн нийт 934 бизнес эрхлэгчдийн дунд санал асуулгын болон онлайн хэлбэрээр 2017 оны 10-12 саруудад явууллаа. Энэ судалгаагаар бизнесийн орчны ерөнхий төлөв байдал, аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого, макро эдийн засгийн үндсэн асуудлууд болох ядуурал, ажилгүйдэл, инфляци, хөрөнгө оруулалтын орчин зэргийн талаар бизнес эрхлэгчдийн байр суурь, цаашид яаж өөрчлөгдөх талаар хүлээлт, бизнесийн орчинд таатай, таагүй нөлөө үзүүлж буй бодлого шийдвэр, бизнесийн орчинг сайжруулах чиглэлд нэн тэргүүнд хэрэгжүүлвэл зохих бодлого, тулгамдаж буй асуудлууд зэрэг эдийн засаг, бизнесийн орчны чухал үзүүлэлтүүдээр судалгаанд оролцогсдын саналыг тоймлон гаргахыг зорьсон болно.

2017 оноос эхлэн олон улсын аргачлалын дагуу бизнесийн орчин, ашиг, орлого, хөрөнгө оруулалт, макро эдийн засгийн орчин гэсэн 4 үзүүлэлтээр судалгаанд оролцогсдын эерэг болон сөрөг хариултын зөрүүгээр Бизнес итгэлийн индексийг тооцон гаргах боллоо. Энэхүү шинэ аргачлалын дагуу сүүлийн таван жилийн индексийг тооцоход 2017 онд өнөөгийн байдлын бизнес итгэлийн индекс нь -0.32 гэсэн дүнтэй гарсан бөгөөд энэ нь 2012 оноос хойш өмнөх онуудаас хамгийн сайн дүн болж байна. Харин “бизнесийн орчин сайжирна” гэсэн бизнес эрхлэгчдийн хүлээлт сүүлийн 4 жилд дунджаар 37% байсан бол энэ жил 58% болж сүүлийн 5 жилээс 2018 онд бизнест хамгийн эерэг жил байна гэж хүлээж байна.

Мөн Дэлхийн банкны эдийн засагчдийн шинжилгээгээр 2018 он нь санхүүгийн хямралаас хойш дэлхийн эдийн засаг бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлж буй эхний жил бөгөөд эдийн засгийн уналт аажмаар сэргэх төлөвтэй байна гэж тайлбарласан. Түүнчлэн энэ үед бодлого боловсруулагчид богино хугацааны өсөлтийг дэмжих зорилгоор төсөв, мөнгөний бодлогын хэрэгслээс гадна урт хугацааны нөөцийг нэмэгдүүлэх санаачилгыг харгалзаж үзэх хэрэгтэй гэж зөвлөмж гаргасныг анхаарах нь зүйтэй.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим

Судалгааны арга зүй

Судалгааг Улаанбаатар хот, орон нутгийн бизнес эрхлэгчдийн дунд асуулгын болон онлайн хэлбэрээр 2017 оны 10-12 саруудад явуулж нийт 934 аж ахуйн нэгжийг хамруулсан.

Судалгааг хийхдээ МҮХАҮТ-ын гишүүд болон гишүүн бус Улаанбаатар хотын 238, 21 аймгаас нийт 696 аж ахуйн нэгжүүдийг хамруулсан болно.

Судалгааг дараах гол 11 салбараар явуулсан



БАЙРШИЛ



24% УЛААНБААТАР
76% ОРОН НУТАГ

ХҮЙС




42%
Эрэгтэй




58%
Эмэгтэй

ОРЛОГО



АЖИЛТНЫ ТОО



Судалгааны үр дүн

НЭГ. БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС

Бизнес эрхлэхэд голлон нөлөөлдөг бизнесийн орчин, ашиг, орлогын өөрчлөлт, хөрөнгө оруулалт, макро эдийн засгийн орчин гэсэн үндсэн 4 үзүүлэлтүүдээр Бизнес итгэлийн индексийг тооцон гаргадаг. 2017 онд анх удаа олон улсын аргачлалын дагуу Бизнес итгэлийн индексийг тооцохдоо үзүүлэлтүүдээр судалгаанд оролцогсдын эерэг, сөрөг үнэлгээний зөрүүгээр тооцон гаргав.

Сүүлийн 5 жилд голлох 4 үзүүлэлтүүд тус бүрээр болон ерөнхий Бизнес итгэлийн индексийг тооцвол 2012-2016 онуудад бизнес эрхлэгчид үйл ажиллагаа явуулж буй орчиндоо итгэх итгэл нь 5 жил дараалан буурсан байна. Харин 2017 онд Бизнес итгэлийн индекс нь -0.32 болж өмнөх оноос 0.85 нэгж функтээр өссөн ба сүүлийн 6 жилээс хамгийн сайн дүнтэй байна.

Хүснэгт 1.1. Бизнес итгэлийн индекс (2012–2017)

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015	2016	2017	Δ
Бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ	0.03	0.04	-0.28	-0.46	-0.36	-0.07	0.29
Ашиг, орлогын өөрчлөлтийн үнэлгээ	0.28	0.11	-0.01	0.10	-0.22	-0.02	0.19
Хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн үнэлгээ	0.50	0.02	-0.10	-0.22	-0.30	0.14	0.44
Макро эдийн засгийн орчны үнэлгээ	-0.23	-0.45	-0.47	-0.46	-0.30	-0.37	-0.07
Бизнес итгэлийн индекс	0.58	-0.27	-0.87	-1.04	-1.18	-0.32	0.85

Индексийг гол үзүүлэлт тус бүрээр авч үзвэл 2017 онд бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээний индекс нь 0.29 функтээр, ашиг орлогын өөрчлөлтийн үнэлгээний индекс 0.19 функтээр, хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн үнэлгээний индекс 0.44 функтээр тус тус өссөн. Харин инфляцийн түвшин, ажилгүйдлийн түвшин, ядуурлын түвшин зэрэг макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдээр тооцон гаргадаг макро эдийн засгийн индекс нь өмнөх оноос 0.07 функтээр буурчээ.

2017 онд гадаад эдийн засгийн таатай нөхцөл бүрдэж уул уурхайн салбар сэргэснээр эдийн засгийн өсөлт, эдийн засгийн идэвхжлийг дэмжин бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлж Бизнес итгэлийн индекс өссөн дүнтэй байна.

Зураг 1.1. Бизнес итгэлийн индекс (2012–2017)




ХОЁР. БИЗНЕСИЙН ОРЧИН

Бизнес эрхлэх таатай, тогтвортой орчин бүрдэж байж бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, цаашид өсөн дэвжих боломж бүрддэг. Иймд бизнес эрхлэгчдийн бизнестээ итгэх итгэлийг тодорхойлох нэг гол үзүүлэлтээр бизнесийн орчинг авч үздэг ба судалгаагаар бизнес эрхлэгчид 2017 онд бизнесийн орчин өмнөх оноос илүү сайжирсан ба 2018 онд илүү сайн орчин бүрдэнэ гэж дүгнэжээ. АНУ-ын ЭСЯ-ны 2017 оны Монгол улсын хөрөнгө оруулалтын баримт бичигт дурдсанаар 2017 онд Монгол улсын засгийн газар, ОУВС-тай хамтран эдийн засгийн хүндрэлийг даван туулах хөтөлбөр хэрэгжүүлэн засгийн газрын төсөв, санхүүгийн шинэчлэл сахилга батыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр гадаад зах зээл дэх өрийг дахин санхүүжүүлэн, улс төр, эдийн засаг бизнесийн таатай орчин бүрдүүлээ гэж үзжээ. Мөн нөгөө талаас экспортын гол түүхий эдийн үнэ дэлхийн зах зээлд өндөр түвшинд хадгалагдан гадаад зах зээлийн таатай нөхцөл бүрэлдсэн, зах зээлд оролцогсдын итгэл нэмэгдсэн шалтгаанууд нь бизнесийн орчны үнэлгээ нэмэгдэхэд нөлөөлжээ.

2.1 Бизнесийн орчны өөрчлөлтийн үнэлгээ


2017 онд бизнесийн орчинг сайжруулахад хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд Бизнес эрхлэгчдийн 65% нь хангалтгүй буюу энэ онд бизнесийн орчин “Муудсан” буюу “Огт өөрчлөгдөөгүй” гэсэн хариулт өгчээ. 2017 онд бизнес эрхлэгчдийн орчны өөрчлөлтөнд өгөх “сайн” үнэлгээ 2016 оноос 13 функтээр өсч 35% хүрчээ. Энэ дүн нь 2013 оноос хойш үзүүлсэн хамгийн сайн үнэлгээ юм. Энэ үнэлгээг компаниудын үйл ажиллагаа явуулж буй байршлаар харвал Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй компаниудын 39%, орон нутгийн бизнес эрхлэгчдийн 33% нь бизнесийн орчин сайжирсан гэж үзжээ.



2.2 Бизнесийн орчны өөрчлөлтийн хүлээлт

Судалгаанд оролцогсдын 58% нь 2018 онд Бизнесийн орчин ямар нэг хэмжээгээр сайжирна гэсэн хариулт өгсөн ба энэ дүнг өмнөх онтой харьцуулбал 30 нэгж хувиар өссөн ба сүүлийн таван жилийн мөн хамгийн сайн үзүүлэлт болж байна. Харин 2017 онд хамгийн их хувь эзэлж байсан “мэдэхгүй” гэсэн бизнес эрхлэгчдийн тодорхойгүй хүлээлт 10 пунктээр буурсан байна.

2018 оныг бизнес эрхлэгчид сүүлийн 5 жилээс хамгийн эерэг жил байна гэсэн хүлээлттэй байгаа ба энэ нь гадаад зах зээлд цэвэр зэс, алт, түүхий нефтийн үнэ харьцангуй тогтмол байна гэсэн гадаад зах зээлийн эерэг хүлээлттэй холбоотой байж болох юм. Бизнес эрхлэгчдийн хүлээлтийг үйл ажиллагааны байршлаар нь харвал Улаанбаатар хотын бизнес эрхлэгчдийн 65%, орон нутгийн бизнес эрхлэгчдийн 56% нь 2018 онд бизнесийн орчин сайжирна гэж хүлээж байна.




ГУРАВ. БИЗНЕСИЙН АШИГ БА ОРЛОГО

Аж ахуйн нэгжүүдийн ашиг орлого нь тухайн улсад хууль эрх зүй, эдийн засаг, бизнесийн орчин нөхцөл хэрхэн бүрдсэнийг илтгэн харуулдаг чухал үзүүлэлт ба бизнес эрхлэх орчин сайжрахын хирээр аж ахуйн нэгжийн ашиг, орлого нэмэгддэг. 2017 онд бизнес эрхлэгчдийн ашиг, орлого өссөн гэж үзсэн бол, 2018 онд ашиг орлого өснө гэсэн хүлээлттэй байна. Монгол банкнаас гаргадаг эдийн засгийн төлөв байдлын судалгаагаар 2017 онд төгрөгийн харьцангуй өгөөж нэмэгдэж, хадгаламжийн долларжилт буурсан, гадаад зах зээлд бондын үнэ өсч байгаа зэрэг шалтгаанаар зах зээлд оролцогсдын итгэл сэргэсэн гэж дурьдсан байна. Магадгүй энэ сэргэлт нь бодитоор бизнес эрхлэгчдийн ашиг орлого 2017 онд өсөх түүнчлэн 2018 оныг эерэгээр төсөөлөх шалтгаан болсон байж болох юм.

3.1. Ашиг, орлогын өөрчлөлт

2017 оны судалгаагаар нийт оролцогсдын 39% нь бизнесийн ашиг нэмэгдсэн гэж үзсэн бол, 43% нь буурсан гэсэн үнэлгээ өгчээ. Харин орлогын хувьд 2017 онд өссөн ба буурсан гэсэн үнэлгээ нь ойролцоо 41% байна.


Эдгээр үнэлгээг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулан нарийвчлан харвал 2016 онд судалгаанд оролцогсдын дөнгөж 15% нь ашиг, орлого ямар нэгэн байдлаар өссөн гэж үзэж байсан бол 2017 онд энэ дүн дунджаар 40 хувь болж 25 нэгж хувиар өссөн дүнтэй байна. 2016 онд 49 орчим хувийг эзэлж байсан огт өөрчлөгдөөгүй, мэдэхгүй гэсэн хариулт 2017 онд дунджаар 18 хувь болж буурсан байна. Харин 2016 онд 36% байсан ашиг орлого буурсан гэсэн үнэлгээ нь 2017 онд дунджаар 42% болж 6 нэгж хувиар өссөн дүнтэй байна. 2017 оны судалгааны дүнгээр ажиглагдсан сонирхолтой үзүүлэлт нь өмнөх жилд “мэдэхгүй, огт өөрчлөгдөөгүй” гэж үзэж байсан судалгаанд оролцогсдын үнэлгээ буурсан бол ашиг орлого “өссөн”, “буурсан” гэх үнэлгээ хоёул өссөн байна. Энэ судалгааны дүнг тодруулах зорилгоор нарийвчлан харвал Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдийн 43% нь ашиг орлого өссөн (37% нь буурсан), орон нутагт үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдийн 39% нь ашиг орлого өссөн (44% нь буурсан) гэж үзжээ.



3.2. Ашиг орлогын өөрчлөлтийн хүлээлт

2016 онд өмнөх оноос 4.4 нэгж хувиар буурч 23.2% болж байсан ашиг орлого өсөх тухай хүлээлт 2017 онд дунджаар 64% -д хүрчээ. 2016 онд судалгаанд оролцсон нийт бизнес эрхлэгчдийн 56% хувийг эзэлж байсан “мэдэхгүй, огт өөрчлөгдөхгүй” гэсэн тодорхойгүй хүлээлт 2017 онд 27% болж бизнес эрхлэгчдийн орчиндоо итгэх итгэл сэргэсэн эерэг үзүүлэлт болж байна.

Үйл ажиллагаа явуулж буй байршлаар нь авч үзвэл Улаанбаатар хотын бизнес эрхлэгчдийн 71% нь 2018 онд бизнесийн ашиг орлого өснө гэж үзэж байгаа бол орон нутгийн бизнес эрхлэгчдийн 62% нь ирэх онд ашиг орлого өснө гэсэн хүлээлттэй байна.



ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН


Монгол улсын гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2015 онд 100 сая ам. долларын алдагдалтай байсан бол 2017 оны эцсээр 1 тэр бум 143 сая ам. долларын ашигтай гарч гадны хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж байгаа эерэг үзүүлэлтүүд ажиглагдаж эхэлсэн. 2017 онд бизнес эрхлэгчдийн бизнестээ оруулж буй хөрөнгө оруулалт өмнөх жилүүдээс эрс нэмэгдсэн, мөн 2018 онд хөрөнгө оруулалт хийх тухай хүлээлт өмнөх оноос 19 нэгж хувиар өссөн дүнтэй байна.

2017 онд хоёр хөршид эдийн засгийн өсөлттэй байснаас шалтгаалан гадаад эрэлт нэмэгдсэн, гол экспортын түүхий эдийн үнэ тогтвортой өндөр түвшинд хадгалагдсан зэрэг нь гадаад зах зээл, худалдааны таатай нөхцлийг бүрдүүлж хөрөнгө оруулагчдийн шийдвэр, хүлээлтэд эерэгээр нөлөөлжээ.

4.1. Хөрөнгө оруулалтын өөрчлөлт


“2017 онд нийт судалгаанд оролцогсдын 57% нь “Хөрөнгө оруулалт хийсэн” гэж хариулсан ба энэ нь өмнөх оноос 22 нэгж хувиар өссөн дүнтэй байна. 2015-2016 онуудад бизнес эрхлэгчдийн бизнестээ оруулсан хөрөнгө оруулалт 2014 онтой харьцуулахад 6-10 нэгж хувиар буураад байсан юм.

Судалгаанд оролцогсдын 57% нь 2017 онд ямар нэгэн байдлаар бизнестээ хөрөнгө оруулалт хийсэн гэсэн хариулт өгсөн нь хүндрэлтэй байгаа эдийн засаг сэргэх дохио олон улсын индекс, үзүүлэлтүүдийн хувьд болон нөгөө талаас бизнес эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн тухай хариултаас харагдаж байна. Хөрөнгө оруулалт нэмэгдэх болсон шалтгаан нь сонгуулийн цикл болоогүй, оруулсан хөрөнгө оруулалтын өгөөжийг хүртэхэд бизнес, эдийн засгийн орчин болон холбогдох хууль тогтоомж харьцангуй тогтвортой байна гэж үзсэнтэй холбоотой байна. 2017 онд Улаанбаатар хотын бизнес эрхлэгчдийн 67%, орон нутгийн бизнес эрхлэгчдийн 54% нь хөрөнгө оруулалт хийсэн гэж хариулжээ.



4.2. Хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн хүлээлт

2018 онд “Та бизнестээ ямар нэг хэмжээгээр хөрөнгө оруулалт хийх сонирхол, боломж байна уу” гэсэн асуултад судалгаанд оролцогсдын 79% нь хөрөнгө оруулалт хийнэ гэсэн эерэг хүлээлттэй байгаа ба энэ нь өмнөх оноос 19 нэгж хувиар өсчээ. 2017 оны хөрөнгө оруулалтын хүлээлт нь сүүлийн 6 жилийн хамгийн өндөр дүн болох 2012 оны 89%-д дөхөж очсон үзүүлэлт болж байна. Бизнес эрхлэгчдийн хүлээлтийг байршлаар нь харвал Улаанбаатар хотын бизнес эрхлэгчдийн 85%, орон нутгийн бизнес эрхлэгчдийн 76% нь ирэх жилдээ хөрөнгө оруулалт хийнэ гэж хариулжээ.



ТАВ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2017 оны судалгаагаар бизнес эрхлэгчид ажилгүйдэл, инфляцийн түвшин өссөн гэж үзсэн бол ядуурлын түвшин тодорхой хэмжээнд буурч байна гэж дүгнэжээ. Харин 2018 онд инфляцийн түвшин буурч, илүү олон ажлын байр бий болж, ядуурлын түвшин ч мөн тодорхой хэмжээгээр буурна гэж хүлээж байна.


2017 онд гадаад дотоодын бизнес, эдийн засгийн орчин тогтворжих хандлагатай байгаа нь бизнес эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэн илүү олон ажлын байр бий болгон өрхийн бодит болон нэрлэсэн орлогын өсөлтийг эрчимжүүлж, ядуурлын түвшинг бууруулахад эерэг нөлөөтэй байна. Нөгөө талаас зах зээлд оролцогсдын итгэл сэргэж, өрхийн бодит орлого өссөн нь эдийн засгийн идэвхжлийг бий болгон инфляцийн түвшин өсөхөд нөлөөлжээ.

5.1 Инфляци

Инфляцийн түвшин нь иргэдийн амьжиргаа, бизнесийн үйл ажиллагаанд хамгийн хүчтэй нөлөөлдөг макро эдийн засгийн нэг гол хүчин зүйл төдийгүй эдийн засаг, бизнесийн орчинг хянах голлох үзүүлэлтүүдийн нэг юм. Нөгөө талаас инфляцийн түвшин өссөнөөр иргэдийн бодит худлдан авах чадвар буурдаг ба энэ бууралт нь мөн бизнес эрхлэгчдийн ашиг, орлогод сөргөөр нөлөөлдөг билээ. 2016 оны эцэст 1.1% -д хүрээд байсан инфляцийн жилийн дундаж түвшин 2017 оны эцсээр 6.4%-д хүрсэн нь эдийн засгийн идэвхжил сэргэж байгааг илтгэн харуулах бас нэгэн дохио болж байна.

Инфляцийн түвшний өөрчлөлтийн үнэлгээ

2017 онд судалгаанд оролцогсдын 46% нь инфляцийн түвшин ямар нэг хэмжээгээр өссөн гэсэн хариулт өгсөн ба энэ нь өмнөх оноос 13 нэгж хувиар өссөн дүн юм. Харин мэдэхгүй буюу тодорхойлох боломжгүй гэсэн үнэлгээ нь 2016, 2017 онд ойролцоо дүнтэй байсан байна.



Инфляцийн түвшний хүлээлт

2018 онд бизнес эрхлэгчид инфляцийн талаар илүү эерэг хүлээлттэй байна. 2018 онд инфляцийн түвшин тодорхой хэмжээгээр буурна гэж нийт судалгаанд оролцогсдын 38% нь таамаглаж байгаа ба энэ дүн нь өмнөх оноос 17 нэгж хувиар өссөн дүн байна.




5.2 Ажилгүйдэл

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2017 онд Монгол улсын 15 ба түүнээс дээш насны хүн ам 2.1 сая болж, тэдний 62% нь эдийн засгийн идэвхитэй хүн ам байгаагаас 92% нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа ба өнгөрсөн оны мөн үеэс 1.8 пунктээр буурсан дүн байна. Нийт ажиллагсдын 30% нь хөдөө аж ахуй, 51.6% нь үйлчилгээ, 18.4% нь үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна. Ажилгүйдлийн дундаж түвшин нь нэг талаас нийгмийн үзүүлэлт мэт боловч нөгөө талаас ажилгүйдлийн түвшин өссөнөөр өрхийн бодит орлого буурч бизнесийн ашиг, орлогод шууд нөлөөтэй байдаг бөгөөд дараа дараагийн бизнесийн шийдвэрт чухал нөлөөтэй макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн нэг юм.


Ажилгүйдлийн түвшний өөрчлөлтийн үнэлгээ

Хүн амын шилжилт хөдөлгөөн ихсэж, ялангуяа Улаанбаатар хотод шилжин ирэх иргэдийн тоо жил ирэх тутам өсч байгаа нь ажилгүйдлийг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байгаа хэдий ч төрийн зохистой, зөв бодлого шийдвэр, үйл ажиллагаа дутагдаж байгааг онцлон анхаарах шаардлагатай. 2017 онд судалгаанд оролцогсдын 51% нь ажилгүйдлийн түвшин өссөн гэсэн хариулт өгсөн ба энэ дүн нь өмнөх оноос 6 нэгж хувиар буурсан байна. Харин ажилгүйдлийн түвшин буурсан тухайн үнэлгээ нь 2017 онд 13 хувь байгаа бол судалгаанд оролцогсдын 36 хувь нь өөрчлөгдөөгүй эсвэл мэдэхгүй гэсэн хариулт өгчээ.



Ажилгүйдлийн түвшний хүлээлт

2017 онд бизнес эрхлэгчид өмнөх оноос илүү олон ажлын байр бий болж ажилгүйдлийн түвшин буурна гэсэн хүлээлттэй байна. 2016 онд ажилгүйдлийн түвшин буурна гэсэн хариулт 28% тай байсан бол 2017 онд энэ үзүүлэлт 37% болж өмнөх оноос 19 нэгж хувиар өссөн дүнтэй байна.




5.3. Ядуурал

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Дэлхийн Банктай хамтран “Ядуурлын дүр төрх-2016” ядуурлын тооцооны үр дүнгээр Монгол улсын ядуурлын түвшин 2014 онд 21.6 хувь байсан бол 2016 онд 29.6 хувьд хүрч 8.0 пунктээр өсчээ. Энэ нь 2016 оны нийт хүн ам болох 3 сая хүнээс 907.5 мянган хүн нь ядууралд өртсөн байгааг илтгэх үзүүлэлт юм.


Ядуурлын түвшний өөрчлөлтийн үнэлгээ

2017 оны судалгаанд оролцогсдын 57% нь ядуурал ямар нэг хэмжээгээр өссөн гэж үзсэн ба өмнөх оноос 14 нэгж хувиар буурсан дүн байна. Харин ядуурлын түвшинг ямар нэг хэмжээгээр буурсан гэж 11% үзсэн ба энэ нь өмнөх оноос 2 нэгж хувиар өссөн дүн байна.



Ядуурлын түвшний хүлээлт

Ядуурлын түвшин жил ирэх тусам өсч байна гэж бизнес эрхлэгчид үзэж байсан бол 2018 онд ядуурлын түвшин өмнөх оноос буурна гэсэн хүлээлттэй байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогсдын 40% орчим нь ирэх жил ядуурал өснө гэж хүлээж байна.



ЗУРГАА. БИЗНЕСИЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Дэлхийн банкнаас орнуудын эдийн засгийн үр ашигтай байдлыг хэмжих зорилготой Бизнес эрхлэлтийн индекс (Doing business index)-ийг гаргадаг. Мөн дэлхийн банкны эдийн засагчдын хийсэн судалгаагаар Бизнес эрхлэлтийн индекс ба тухайн орны бүтээмж нь хоорондоо эерэг хамааралтай байдаг бөгөөд Бизнес эрхлэлтийн индекс өндөртэй орон нь илүү өндөр бүтээмжтэй байдаг байна. Өөрөөр хэлбэл бизнесийн тогтвортой, сайн орчин нь илүү өндөр бүтээмжийг бий болгодог байна. Иймд энэ хэсэгт тогтвортой, таатай бизнесийн орчинг бүрдүүлэхэд хамгийн түрүүнд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, бодлого шийдвэрийн тухай судалгаанд оролцогсдын үнэлгээг нэгтгэлээ.

	Зээлийн өндөр хүү/ богино хугацаа (17%)
	Бодлогын тогтворгүй байдал (15%)
	Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт) (11%)
	Хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал (9%)
	Авилга, хээл хахууль (9%)
	Төрийн албаны нүсэр бүтэц (9%)
	Төрийн хүнд суртал (9%)
	Буруу мөнгөний бодлого (8%)
	Мэргэжлийн, тогтвортой ажиллах хүчний дутагдал (7%)
	Шударга бус тендер шалгаруулалт (7%)

Бизнес эрхлэгчдээс бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр хамгийн түрүүнд өөрчилж сайжруулах шаардлагатай гэж үзсэн асуудлуудын 2016 ба 2017 онуудын эрэмбийн өөрчлөлтийг дараах хүснэгтээр үзүүлэв.

2017	Ранк	2016
Зээлийн өндөр хүү/ богино хугацаа	1	Төрийн хүнд суртал
Бодлогын тогтворгүй байдал	2	Авилга хээл, хахууль
Татварын хувь, хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт)	3	Зээлийн өндөр хүү/богино хугацаа
Хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал	4	Төрийн албаны нүсэр бүтэц
Авилга, хээл хахууль	5	Шударга бус тендер шалгаруулалт
Төрийн албаны нүсэр бүтэц	6	Олон татвар, хураамж
Төрийн хүнд суртал	7	Хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал

Бизнес итгэлийн индексийн голлох үзүүлэлтүүдийн чиг хандлага


БИЗНЕСИЙН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ

2012 оноос хойш тогтмол буурах хандлагатай байсан "Бизнес орчны өөрчлөлт"-ийн үнэлгээ сүүлийн 6 жилийн хамгийн сайн үнэлгээг үзүүлсэн байна.




АШИГ ОРЛОГО

2012 оноос хойш тасралтгүй буураад байсан ашиг орлого өссөн үнэлгээ болон ирэх жилд өсөх тухай хүлээлт нь 2017 онд сүүлийн 6 жилд анх удаа өмнөх оноос өндөр өссөн дүнтэй байна.




ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ


2017 онд бизнес эрхлэгчдийн хөрөнгө оруулсан болон дараа жилд хөрөнгө оруулна гэсэн эерэг үнэлгээ өмнөх оноос өссөн дүнтэй байна.




ИНФЛЯЦИЙН ТҮВШИН



АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН



ЯДУУРЛЫН ТҮВШИН



2017 оны судалгааны дүнгээр инфляци, ажилгүйдлийн түвшин өмнөх оны түвшинтэй харьцуулахад тодорхой хэмжээнд суурсан боловч бизнес эрхлэгчдийн хүлээлтэд хүрээгүй байна. Ирээдүйд эдгээр түвшин нь мөн буурна гэж таамаглаж байна.

Дүгнэлт


Гадаад зах зээлийн эерэг нөлөө, дотоод эдийн засагт ажиглагдсан макро болон микро түвшний сэргэлтүүд, засгийн газрын бодлого тогтворжин, төсөв санхүүгийн сахилга бат сайжирсан зэрэгтэй холбогдуулан гадаад, дотоод бизнесийн орчин өмнөх жилүүдээс сайжирч, бизнес эрхлэгчдийн итгэл нэмэгдэн 2017 оны бизнес итгэлийн индекс -0.32 гарсан бөгөөд энэ нь өмнөх оноос 0.85 пунктээр өссөн байна.

Индекс тооцож буй гол үзүүлэлтүүдээр нарийвчлан авч үзвэл макро эдийн засгийн орчноос бусад 3 үзүүлэлтүүд өмнөх оноос сайжирсан гэж үнэлсэн байна. Бизнесийн орчин өмнөх жилээс ямар нэгэн хэмжээгээр сайжирсан гэсэн хариултыг нийт судалгаанд оролцогсдын 35% нь хариулсан бол 57% нь ирэх жил илүү сайн бизнесийн орчин бүрдэнэ гэсэн хүлээлттэй байна. Харин бизнесийн орчинг хэмжих бодит үзүүлэлтүүд болох ашиг, орлогын хэмжээ 2017 онд дунджаар 40 хувь өссөн гэж үзжээ. Мөн судалгаанд оролцогсдын 42% нь 2017 онд бизнесийн ашиг орлого өмнөх оноос “буурсан” гэж үзсэн ба компаниудын үйл ажиллагааны байршлаар нарийвчлан харвал орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчид илүү муу үнэлгээ өгсөн байна. 2018 оныг бизнес эрхлэгчид бизнесийн ашиг орлогод эерэг нөлөө үзүүлсэн таатай жил байна гэж төсөөлж байна.

Өөр нэг анхаарал татахуйц үзүүлэлт нь 2016 онд бизнес эрхлэгчдийн 60% нь 2017 оны хөрөнгө оруулалтын орчинг эерэгээр төсөөлж тухайн онд ямар нэг хөрөнгө оруулалт хийх хүлээлттэй байсан бол 2017 оны судалгаагаар тухайн оны хөрөнгө оруулалтын орчны гүйцэтгэлийн үнэлгээнд 57%-ийн эерэг дүн өгчээ. Өөрөөр хэлбэл 2017 оны хөрөнгө оруулалтын орчны хүлээлт, үнэлгээ хоёр нилээн ойролцоо гарсан байна. Бизнес эрхлэгчид 2018 оныг хөрөнгө оруулалт хийхэд илүү сайн орчин бүрдсэн жил байна гэж үзэж байгаа бөгөөд нийт судалгаанд оролцогсдын 79 хувь нь ямар нэг байдлаар хөрөнгө оруулалт хийнэ гэжээ. Гадаад зах зээлд худалдааны нөхцөл сайжирсан, гадаад дотоод санхүүжилтийн дарамт буурч, хөрөнгө оруулагчдийн итгэл сэргэсэн нь хөрөнгө оруулалтын орчны итгэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Макро эдийн засгийн чухал үзүүлэлтүүд болох инфляци, ажилгүйдлийн түвшинг 2017 онд өмнөх оноос хангалттай буураагүй гэж үзсэн ба ядуурлын түвшинг энэ онд тодорхой хэмжээгээр буурсан гэж дүгнэжээ.

2017 онд бизнесийн орчинг тааламжтай болгоход зээлийн өндөр хүү (17%), бодлогын тогтворгүй байдал (15%), татварын хувь хэмжээ (11%) зэрэг нь хамгийн тулгамдаж буй асуудлууд гэж нэрлэжээ.



Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим,
МҮХАҮТ-ын байр, М.Гандигийн гудамж, 15-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17011, UB Post – 101011001

Утас: +976-11-310619

Факс: +976-11-324620

e-mail: policy@mongolchamber.mn

www.mongolchamber.mn